хувь нэмрийг нь үнэлж "МИАТ" ХК-ийн Боинг-В737-800 онгоцны дарга Ринчингийн Батнасанд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

### Бадамжавын Чогсомд Монгол Улсын ардын зураач цол хүртээх тухай

Боловсрол, мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан, уран сайхны шинэ эрэл хайгуул хийж, түүх, ажил хөдөлмөр, хөрөг, байгалийн сэдэвт шилдэг уран зураг олныг туурвиж, монголын дүрслэх урлагийг хөгжүүлэх, алтан сан хөмрөгийг баяжуулах, залуу уран бүтээлчдийг сургаж бэлтгэхэд оруулсан дорвитой

хувь нэмрийг нь үнэлж Монголын орчуудын эвлэлийн зураач Бадамжавын Чогсомд Монгол Улсын ардын зураач цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

### Банзарын Дамчаад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Урлаг, соёлын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, уран сайхны киноны гол ба туслах дүрүүдийг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг бүтээхийн зэрэгцээ кино зохиол бичиж найруулан, гадаадын киног эх хэлнээ орчуулан дуу оруулж, монголын кино урлагийг хөгжүүлэхэд

оруулсан бодитой хувь нэмрийг нь үнэлж жүжигчин Банзарын Дамчаад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

### Пагважавын Нямдаваад Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбар, төрийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж эрүүл мэндийн салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, хүн амын эрүүл мэндийн тусламжийн чанар хүртээмжийг дээшлүүлэх, эрүүл мэндийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Халдварт өвчин судлалын

үндэсний төвийн зөвлөх, академич Пагважавын Нямдаваад Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

### Нацагийн Хавхад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж философийн шинжлэх ухаанд шинэ сэтгэлгээ, арга зүйг бий болгох, нийгмийн хөгжлийн онолыг шинэчлэх, монголын нийгмийн хөгжлийн онол, бодлогын үзэл баримтлалыг боловсруулахад чиглэгдсэн бүтээлүүд туурвиж, социологийн шинжлэх ухаан, буддын гүн ухааны судлалыг үүсгэн хөгжүүлэхэд

оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн философийн тэнхмийн багш, доктор, профессор Нацагийн Хавхад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

### Довдойн Баярт Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, эртний нүүдэлчдийн түүх соёлын дурсгалыг судлах, сурталчлах, хадгалж хамгаалах, монголын археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрдэмтэн судлаачдын залгамж халааг бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ШУА-

ийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор, профессор Довдойн Баярт Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

### Самдангийн Лувсанноровт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсрол, төр захиргаа, төрийн бус байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсын боловсрол, соёл, нийгмийн хөгжил, дэвшилд оруулсан хувь нэмрийг үнэлж ахмад

ажилтан Самдангийн Лувсанноровт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

### Эрдэнийн Бямбажавт Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай

Төр захиргаа, санхүү, эдийн засгийн төв байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсын эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, төрийн сангийн удирдлага, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, санхүүгийн системийг боловсронгуй болгоход оруулсан хувь нэмрийг

үнэлж "Их тусч" ХХК-ийн захирал Эрдэнийн Бямбажавт Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

### Далайн Дашжамцад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, шинжилгээ-судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж, дээд боловсролтой инженер техникийн боловсон хүчнийг бэлтгэх ажлыг удирдан зохион байгуулах, барилгын салбарын зах зээлийн эрэлтэд нийцсэн сургалтын стандартыг шинэчлэх, сургалтын арга барилыг боловсронгуй болгоход оруулсан хувь нэмрийг нь

үнэлж ШУТИС-ийн эрдэм шинжилгээ технологийн проректор, догтор, профессор Далайн Дашжамцад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

### Нанжаагийн Лхагвад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж сэтгүүл зүйн олон төрлөөр шилдэг бүтээлүүд бичиж туурвин, сэтгүүл зүй, ардчилал, чөлөөт хэвлэлийн хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлж сэтгүүлч, орчуулагч

Нанжаагийн Лхагвад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

### Балжирын Догмидод Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллага, утга зохиолын салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, шилдэг кино, тууж, өгүүллэг, хөрөг нийтлэлүүд туурвиж, монголын утга зохиолын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

зохиолч Балжирын Догмидод Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

### Гүнчингийн Дашганд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэн, багш, сурагчдын ажиллаж, суралцах таатай орчинг бүрдүүлж, боловсролын шинэчлэлийг ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх шинэ загвар боловсруулан мөрдөж, сургалтын арга барилыг

боловсронгуй болгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 24 дүгээр сургуулийн ахмад багш Гүнчингийн Дашганд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 255

Улаанбаатар хот

### Даваасүрэнгийн Дамбалэлжээд Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээх тухай

Түлш эрчим хүч, уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, уул уурхайн салбарт тэргүүний арга барил, шинэ техник технологийг нэвтрүүлэн, уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Багануур" ХК-ийн гүйцэтгэх захирал

Даваасүрэнгийн Дамбалэлжээд Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

### Сүхбаатарын Пүрэвжавт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн материаллаг баазыг бэхжүүлэн шинэ тоног төхөөрөмжөөр хангаж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулан хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн их эмч Сүхбаатарын Пүрэвжавт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

### Балжийн Лхагваад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Орон нутгийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ардын болон зохиолын дуу, үндэсний сонгодог дуурийн ари романсыг мэргэжлийн өндөр түвшинд дуулж, уран бүтээлийнхээ санг баяжуулан, монголын дууны урлагийг өөрийн оронд төдийгүй гадаад орнуудад сурталчлах, залуу дуучид, уран бүтээлчдийг

сургаж, бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын гоцлол дуучин Балжийн Лхагваад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 258

Улаанбаатар хот

### Лувсангийн Самбалхүндэвт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлаг, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, ардын үлээвэр хөгжмийн зэмсгийг чадварлаг эзэмшин дэлхийн сонгодог болон үндэсний хөгжмийн зохиолуудыг гоцлон тоглож, үндэсний хөгжмийг гадаад оронд сурталчлах, окутан залуучуудад сургаж, өвлүүлэх, төрийн үндэсний их найрал хөгжмийг

үүсгэн байгуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Хөгжим, Бүжгийн коллежийн хөгжмийн багш Лувсангийн Самбалхүндэвт Монгол Улсын Урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 259

Улаанбаатар хот

### Чулууны Чинбатад Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, монголын хөгжмийн урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчлах, хөгжмийн урлагийн өндөр зэрэглэлийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөгжим, Бүжгийн коллежийн багш

Чулууны Чинбатад Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

### Моёбуугийн Булганд Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан, олон шилдэг нийтийн дууг мэргэжлийн өндөр түвшинд зохиож, монголын хөгжмийн урлагийг хөгжүүлэх, урлагийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөгжим, Бүжгийн

коллежийн багш Моёбуугийн Булганд Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

### Энхбатын Бадар-Ууганд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Сонирхогчдын боксын спортын төрлөөр тив, дэлхий, олон улс болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, Ази тивийн аваргын алт, дэлхийн аваргын мөнгөн медаль хүртсэн амжилтыг нь үнэлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд" спорт

хорооны тамирчин Энхбатын Бадар-Ууганд Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

### Кувейт Улсын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, Кувейт Улсын харилцаа, нэмрийг нь үнэлж Кувейт Улсын иргэн дараах хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оруулсан хувь хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

#### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Шейх Нассер Сабах Аль-Ахмад Аль Сабах - Кувейт Улсын Эмирийн тамгын газрын хэрэг эрхлэх сайд  
2. Бадэр Мешари Аль-Хумайди - Кувейт Улсын газрын тосны сайд

#### "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:

Хишам Ибрахим Аль Вакаяан - Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн дэд захирал

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ХЯНАН ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд Ж.Амарсанаа, П.Очирбат /илтгэгч/, Ж.Болдбаатар, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

"Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т "Чуулган нь нэгдсэн хуралдаан, байнгын хороодын дагнасан буюу хамтарсан түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ" гэж заасан нь дор дурдсан байдлаар Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог нар оролцов.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ", Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна" гэж тус тус заасан байдаг. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь ийнхүү Үндсэн хуульд заасны дагуу хууль тогтоох онцгой бүрэн эрхээ "чуулган" гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрээрээ хэрэгжүүлж байдаг бөгөөд харин чуулган /ээлжит/ нь хагас жилдээ нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулах талаар заасан байна.

Хуралдаанаар Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин долдугаар зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг, Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

Уг заалтад "Улсын Их Хурал чуулна" гэж заагаагүй байх бөгөөд харин "Улсын Их Хурлын

“чуулган” “чуулна” гэж түүний зохион байгуулалтын үндсэн хэлбэрийг тодотгож заасан нь ихээхэн анхаарал татаж байдаг юм. “Чуулна” гэдэг үг нь өөрөө цуглана, хуралдана гэсэн үгнүүдтэй ижил утгыг илэрхийлж байдаг бөгөөд эдгээр утгын хүндэтгэсэн илэрхийлэл юм. Тиймээс “чуулган чуулна” гэснийг “чуулган хуралдана, өөрөөр хэлбэл чуулганы хуралдаан болно” гэж ойлгож болох юм.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэрийг “чуулган” гэж нэрлэж байхаар тогтоосон бөгөөд уг зохион байгуулалтын хэлбэрийн заавал хуралдах өдрийн доод хязгаарыг тодорхой зохицуулан заажээ. “Чуулган” нь Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлдэг үндсэн хэлбэрийн хувьд зохион байгуулалтын бусад хэлбэрүүдээсээ ялгаатай байдаг. Тийм ч учраас Үндсэн хуулийн холбогдох заалтад “...чуулган ... чуулна” хэмээн зохион байгуулалтын бусад хэлбэрээс тодотгон заасан нь санамсаргүй орсон заалт биш бөгөөд Монгол Улсын Их Хурлыг байнгын ажиллагаатай парламент болгосон ихээхэн үнэ цэнэтэй заалт юм.

Чуулганы үйл ажиллагааны хэлбэр нь олноороо хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэдэг ардчилсан зарчимд тулгуурласан хуралдаан л байдаг учраас чуулган ба түүний хуралдаан /чуулганы хуралдаан/ гэсэн ойлголтууд нь хоорондоо ялгаагүй нэг л ойлголт гэж үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болдог чуулган гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрт зохион байгуулалтын бусад хэлбэрийг багтаах болсон Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг шууд утгаараа зөрчиж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн уг заалтад заасны дагуу байнгын хороо, нам, эвслийн бүлэг хуралдсан нь чуулганы үйл ажиллагааны нэг хэсэг болж улмаар тухайн өдөрт чуулган чуулснаар /хуралдсанаар/ тооцуулах болсон нь чуулганы заавал чуулах /хуралдах/ өдрийн доод хязгаарыг заасан Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна”, мөн уг зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы ... хуралдааныг гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, ...” гэсэн заалттай агуулгын хувьд нийцэхгүй байна.

“Байнгын хороо”-ны хуралдаан нь чуулган гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрийн нэг бүрэлдэхүүн болж, Улсын Их Хурлын тухай хуульд хуульчлагдсан нь байнгын хороо Улсын Их Хурлын бие даасан зохион байгуулалтын хэлбэр байх тухай Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар чиглэлээр байнгын хороодтой байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ийнхүү Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

“Чуулган нь нэгдсэн хуралдаан, байнгын хорооны дагнасан буюу хамтарсан түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ” хэмээн зааснаас улбаалж “чуулганы нэгдсэн хуралдаан” гэсэн ойлголт бий болсон бөгөөд цаашлаад “чуулганы байнгын хорооны хуралдаан”, “чуулганы нам, эвслийн бүлгийн хуралдаан” гэсэн ойлгомжгүй нэр, томъёо үүсэх нөхцөл байдал бий болоод байгаа юм. Улсын Их Хурлын “...байнгын хороо”-ны хуралдаан, Улсын Хурал дахь нам, эвслийн бүлгийн хуралдаан гэж байхаас чуулганы байнгын

хорооны хуралдаан, чуулганы нам, эвслийн бүлгийн хуралдаан гэсэн ойлголт байдаггүй билээ.

Монгол Улсын Үндсэн хуулинд байнгын хороо гэсэн Улсын Их Хурлын зохион байгуулалтын бие даасан хэлбэр байх талаар заасан бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг нь зөвхөн Улсын Их Хурал тогтоож байхаар заасан байна.

Нам, эвслийн бүлгийн хуралдаан нь чуулганы нэг хэсэг болсноороо нам, эвслийн бүлэгт харьяалагддаггүй гишүүдийн эрх ашиг хөндөгдөж байгаа бөгөөд тухайлбал Үндсэн хуульд заасны дагуу тодорхой хугацаанд чуулах /хуралдах/ ёстой чуулганы ажиллагаанд /хуралдаанд/ бүрэн гүйцэд оролцох боломжгүй болж байгаа юм.

Анхны Улсын Их Хурлын тухай хуулиудад "байнгын хороодын хуралдааныг чуулганы ажиллагаанд тооцно" гэж зааж байсан бол 2001, 2006 онуудад шинэчлэгдэн батлагдаж гарсан Улсын Их Хурлын тухай хуульд байнгын хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаан нь чуулганы бүрэлдэхүүн байх тухай заасан байна. Тухайн үеийн Улсын Их Хурлын холбогдох заалт нь өөр хоорондоо адилгүй найруулагдсан байх боловч байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн хуралдааныг чуулганы үйл ажиллагаанд, өөрөөр хэлбэл чуулган чуулсанд /хуралдсанд/ тооцуулж байгаагаараа ижил агуулгатай юм" гэжээ.

**Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлын

бүрэн эрхэд хамаарах Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх аливаа асуудлаар байнгын хороо, нам, эвслийн бүлэг өөрийн байр сууриа илэрхийлж санал, дүгнэлт гаргах эрхтэй байдаг. Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг ийнхүү парламентын зохион байгуулалтын бүтцэд оруулсан нь манай улсад 1990 оноос эхэлсэн ардчилсан эрх зүйт төрийн тогтолцооны зарчмыг хэрэгжүүлж улмаар Үндсэн хуулиндаа батлан тунхагласан юм. Өөрөөр хэлбэл нам төвтэй төрийн байгуулалтаас ардчилсан төрийн байгуулалтад шилжин Улсын Их Хурлыг ард түмний нэрийн өмнөөс төрийн эрхийг барьж тус орны гадаад, дотоод бодлогын үндсийг тогтоож буй төрийн эрх барих дээд байгууллага мөн гэж тогтоож өгсөн.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална." гэж заасан байдаг. Иймд Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг тухайн нам, эвслийн бүлгээс нэр дэвшин сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдээс бүрддэг бөгөөд Улсын Их Хуралд сонгогдоогүй гадуур байгаа хүчин төрийн бодлогыг тодорхойлохгүй. Хоёрт нам, эвслийн бүлэг зөвхөн санал, дүгнэлт гаргах бөгөөд шийдвэрийг Улсын Их Хурал гаргадаг юм.

Иргэн Н.Ариунболдын "чуулган" гэдэг нь "хуралдаан" байна гэсэн үндэслэлийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байна. Улсын Их Хурал буюу парламентын үйл ажиллагааны гол чухал хэлбэр бол "хуралдаан" бөгөөд асуудлыг цөөнхийн саналыг харгалзан олонхийн санал хурааж шийдвэрлэдэг. Улсын Их Хурал өөрөө 76 гишүүнээс бүрддэг. Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1-д

"Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна" гэж заасан.

Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган буюу "хуралдаан" гэсэн хэлбэрээр хэрэгжүүлнэ. Байнгын хороо, нам, эвслийн бүлэг гишүүдээс бүрдэнэ. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд хуралдана гэсэн үг юм.

Улсын Их Хурал чуулганаараа төрийн гадаад, дотоод бодлогын, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн, төрийн байгуулалтын асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхдээ хуралдахаас гадна Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцүүлэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын ажилтай танилцах, иргэдийг хүлээн авч уулзах, хүсэлтийг нь сонсож холбогдох арга хэмжээ авах зэргээр олон төрлийн асуудлыг шийдвэрлэдэг болно.

Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлын чуулган бол хуралдаанаас гадна байнгын хороо, Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг нэгэн адил хамаардаг цогцолбор ойлголт юм.

Нам, эвслийн бүлэг нь Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр бөгөөд Улсын Их Хурлын бүтцэд хамаарч байдаг тул түүний эрх, үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалтын бусад асуудлыг нэгэн адил Улсын Их Хурлын тухай хуулиар зохицуулж байдаг.

Тийм ч учраас эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцахгүй байхаар хуульчлан заасан. Бүлэг нь байнгын хороотой адил хуралдаан хийж байж төсөл болон бусад асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зэргээр тодорхой эрх, үүрэгтэйгээр ажилладаг тул аливаа чуулган зарлагдсан хугацаанд нам, эвслийн бүлэг тодорхой цаг хугацаанд хуралдаанаа хийх шаардлагатай байдаг.

Энэ утгаараа Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг гишүүдийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр гэж ойлгож Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, ...зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно" гэж заасантай нийцнэ гэж үзэж байна" гэжээ.

#### **ҮНДЭСЛЭЛ:**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэж зааснаас үзэхэд "чуулган" нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр болох нь тодорхой байна. Энэ нь ч Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т нэгэн адил хуульчлагджээ.

Аливаа улс төрийн намын зорилго нь сонгуульд дангаар буюу хамтран /эвсэл/ оролцож өөрийн дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадамж бүхий суудлыг парламентад бүрдүүлэх явдал байдаг. Түүнчлэн "нам, эвслийн бүлэг" гэх Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Үндсэн хуульд

хуульчилснаас гадна нам, эвслийн бүлэг нь зөвхөн тухайн сонгуулийн дүнд бий болж болохоор зохицуулсан байна. Нам, эвслийн бүлгийг Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслээс ийнхүү Үндсэн хуулиар ялгамжтайгаар хуульчилсан нь парламентат ёсны мөн чанар, парламентын намууд болон түүний эрх хэмжээ, чиг үүрэгтэй салшгүй холбоотой юм.

Монгол Улсын Үндсэн хуульд олон намын тогтолцоонд үндэслэсэн байнгын ажиллагаатай парламентийн үндсийг бий болгосон бөгөөд Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэр болох "чуулган"-д нам, эвслийн бүлгийн хуралдаан хамаарахгүй гэсэн үзэл баримтлал илэрхийлэгдэхгүй байна. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүтэцэд нэгэнт хамаарч байгаа тул түүний хуралдааныг чуулганы бүрэлдэхүүнд оруулсан нь үндэслэлтэй байна.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т "Чуулган нь ... түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хууль дээдлэх... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн". Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ", 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна", Далдугаар

зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон

#### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т "Чуулган нь ... түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ" гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин долдугаар зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ****Н.ЖАНЦАН****ГИШҮҮД****П.ОЧИРБАТ****Ж.АМАРСАНАА****Ж.БОЛДБААТАР****Ц.САРАНТУЯА**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2.5